



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/105

Даланзадгад сум

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 8 дугаар зүйл, 6 дугаар бүлгийн 6.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 7 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг шинээр олгосон, хугацааг сунгасан эрүүл мэндийн байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагад, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, тусламж үйлчилгээнд мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллахыг эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга (Ж.Отгонбайгал)-д даалгасугай.

3. Тусгай зөвшөөрлийн комиссоос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, тайлагнаж ажиллахыг тусгай зөвшөөрлийг шинээр олгогдсон, сунгасан эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Б.Мидэрсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЖАВЗАНДУЛАМ



Эрүүл мэндийн газрын даргын  
2023 оны 12 сарын 25 -ны өдрийн  
А/1105 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОСОН, ХУГАЦААГ СУНГАСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭРС

Д/д	Байгууллагын нэр, тусгай зөвшөөрлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	хугацаа	ТЗ хүчинтэй хугацаа	Хаяг байршил
1. Тусгай зөвшөөрлийг шинээр олгосон					
1.	Говь дент УТҮГ Говь дент шүдний төв ЭМХ-23/46/147	Шүдний тусламж үйлчилгээ	3 жил	2026 оны 12 сарын 22	Даланзадгад сум 5-р багийн төвийн байр
2.	Гиваа дэлэг санчир ХХК Сонор мед эмнэлэг ЭМХ-23/46/148	Чих хамар хоолойн оношилгоо эмчилгээ	3 жил	2026 оны 12 сарын 22	Цогтцэций сум Цагаан-Овоо 3-р баг өрхийн ЭМТ -н байр
3.	Ерөөгдсөн говь ХХК Ерөөл эмийн сан ЭСХ-23/46/149	Нийтийн үйлчилгээтэй II зэрэглэлийн эмийн сан	3 жил	2026 оны 12 сарын 22	Даланзадгад сум 9-р баг Гурван сайхан хорооллын 7 дугаар гудамж 11 тоот
2. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан					
4.	Монос Өмнөговь ХХК Монос -Даланзадгад эмийн сан ЭСХ -21/14/115	Нийтийн үйлчилгээтэй II зэрэглэлийн эмийн сан	5 жил	2029 оны 1 сарын 29	Даланзадгад сумын 3-р байр, 101 тоот
5.	Сүжийнговь ОНӨААТҮГ Сүжийнговь эмийн эргэлтийн сан ЭЭС -06/14/32	Нийтийн үйлчилгээтэй II зэрэглэлийн эмийн сан	5 жил	2029 оны 2 сарын 20	Баян-Овоо сумын төв
6.	Азифарма говь ХХК Азифарм Ханбогд эмийн сан ЭСХ-21/14/126	Нийтийн үйлчилгээтэй II зэрэглэлийн эмийн сан	5 жил	2028 оны 11 сарын 18	Ханбогд сум 2-р баг Гавилууд цаг уурын 1-1 тоот